

**“СҮРЬЕЭ БОЛОН ЯМ ӨВЧНИЙ ХЯНАЛТ” ТӨСЛИЙН ХАМТАРСАН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ АНХДУГААР ХУРАЛД ТӨСЛИЙН ЗАХИРАЛ  
Д. БАЯРБОЛДЫН ХЭЛЭХ ҮГИЙН ТӨСӨЛ**

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Юуны өмнө Япон-Монголын улсын хамтран хэрэгжүүлж буй "Сүрьеэ болон ям өвчний хяналт" САТРЕПС төслийн Хамтарсан зохицуулах Хорооны анхдугаар хуралд оролцож байгаа та бүхэнд талархал илэрхийлье.

Монгол Улсын Засгийн газар Япон улсын Хоккайдогийн их сургууль, Сүрьеэ судлалын хүрээлэнтэй хамтран 2020-2025 онд хэрэгжүүлэх “Сүрьеэ болон ям өвчний хяналт” төслийг ЖАЙКА олон улсын байгууллагад 2018 оны 10 сард өргөн барьсан билээ.

Японы олон улсын ЖАЙКА байгууллага, Эрүүл мэндийн судалгаа, хөгжлийн байгууллагын хамтарсан "Тогтвортой хөгжлийн төлөө шинжлэх ухаан, технологийн судалгааны түншлэл" (САТРЕПС)-ийн хүрээнд энэхүү төслийг баталсан бөгөөд Монгол Улсын талаас Халдварт өвчин судлалын үндэсний төв, Мал эмнэлгийн хүрээлэн, Япон Улсын Хоккайдогийн их сургууль, Японы сүрьеэ судлалын хүрээлэн хамтран 2020 оны 11 сараас эхлэн хэрэгжүүлж эхлээд байна.

Тус төслийн захирлаар Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга Баярболд миний бие ажиллах бөгөөд төслийн Хамтарсан зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнд Сангийн яам, Боловсрол шинжлэх ухааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Мал эмнэлгийн ерөнхий газар, Шинжлэх ухаан технологийн газар, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Хөдөө аж ахуйн их сургууль болон Японы олон улсын ЖАЙКА байгууллага, Хоккайдогийн их сургууль, Японы Сүрьеэ судлалын хүрээлэн зэрэг холбогдох байгууллагын албаны хүмүүс орсон байна.

Өнөөдөр бид Хамтарсан зохицуулах зөвлөлийн анхдугаар хурлыг зохион байгуулж, төслийн хэрэгжилтэд тулгарч байгаа бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар санал солилцохоор цуглараад байна.

Тус төслийн үр дүнд хүний сүрьеэ, адууны ям өвчний тархалтыг хянахад шаардлагатай шинжлэх ухааны үндэслэл бүхий арга замыг тодорхойлон улмаар “Нэг эрүүл мэнд” санаачилгын хүрээнд зоонозын өвчнийг нарийвчлан судлах шинжлэх ухааны түшиц баазыг Монгол Улсад байгуулахад ихээхэн ахиц, дэвшил авчирна гэж бид хүлээж байгаа юм.

2020 оноос дэлхий дахинд гарч байгаа коронавируст халдварын цар тахлын нөхцөл байдал САТРЕПС төслийн хэрэгжилтэд нөлөөлсөн хэдий ч хоёр талын гүйцэтгэгч байгууллагууд өөрийн нөөц, бололцоогоо дайчлан даван туулсаар ирсэнд нь талархал илэрхийлж байна.

Өнөөдрийн хурлын төгсгөлд дээр дурьдсаны дагуу төслийн хэрэгжилтэд тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэх арга замын талаар хоёр тал саналаа солилцон, төлөвлөгдсөн ажлыг эрчимтэй хэрэгжүүлэх талаар зөвшилцөж, тодорхой шийдэлд хүрнэ гэдэгт итгэж байна.

Хурлын ажилд амжилт хүсье